Хүүгийн орлого	3483.5	860.8	24.7	-2622.6
Төсөвт байгууллагын өөрийн орлого	17100.6	12148.4	71.0	-4952.1
Торгуулийн орлого	10873.7	6414.6	59.0	-4459.1
Түрээсийн орлого	993.4	893.5	89.9	-99.9
Бусад нэр заагдаагүй орлого	10939.2	12438.7	113.7	1499.5
Өмч хувьчлалын орлого	22350.0	8147.5	36.5	-14202.5
3. Хандив тусламжийн орлого	3635.5	0.0	-	-3635.5
4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	188694.3	186416.4	98.8	-2277.8
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	175239.1	173737.1	99.1	-1502.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	13455.2	12679.3	94.2	-775.9

Зураг 22. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн нийт зарлагын 25.2 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 2.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 18.5 хувийг нийгмийн халамжийн үйлчилгээ болон нэг удаагийн тэтгэмж урамшуулал, 21.9 хувийг хөрөнгийн зардал, 31.7 хувийг бараа ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 16. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хувь	зөрүү	
Багануур	7059.5	10232.9	8804.6	86.0	132.7	-1745.1
Багахангай	1847.5	3667.4	2574.0	70.2	-1093.4	-726.5
Баянгол	38554.3	43522.9	37501.8	86.2	-6021.1	1052.6
Баянзүрх	46459.7	52687.1	44171.6	83.8	-8515.5	2288.1
Налайх	7414.0	10509.1	9756.4	92.8	-752.7	-2342.4
Сонгинохайрхан	39782.2	44650.2	39245.6	87.9	-5404.6	536.6
Сүхбаатар	41890.5	47689.0	34167.3	71.6	-13521.7	7723.2
Хан-Уул	30726.1	35199.7	26757.3	76.0	-8442.4	3968.8
Чингэлтэй	37838.7	39246.1	30509.1	77.7	-8737.0	7329.6
Нийслэлийн шууд	262427.0	543449.1	288038.1	53.0	-255411.0	-25611.1
Нийт дүн	513999.4	830853.4	521525.8	62.8	-309327.7	-7526.4

Хүснэгт 17. Өглөгтэй дүүргүүд, сая төгрөг

	8-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	8-р сарын эцсийн үлдэгдэл
Багануур	52.2	10.9	6.8	56.3
Багахангай	2.4	3.9	0.0	6.3
Баянгол	386.9	31.2	145.8	272.4
Баянзүрх	299.9	10.3	219.1	91.2
Налайх	41.6	44.4	5.5	80.5
Сонгинохайрхан	225.4	25.4	125.8	125.0
Сүхбаатар	190.9	22.8	73.7	140.0
Чингэлтэй	7.5	14.4	6.9	15.1
Хан-Уул	39.4	33.6	0.5	72.5
Нийслэлийн шууд	165.4	0.0	0.0	165.4
Нийт	1411.7	196.9	584.0	1024.7

Нийслэлийн төсөв болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд сарын эхэнд 1411.7 сая төгрөгийн өглөгтэй байснаас тайлант хугацаанд шинээр 196.9 сая төгрөгийн өглөг үүсч, тухайн сард 584.0 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан, сарын эцэст 1024.7 сая төгрөгийн өглөгтэй үлдсэн байна.

Хүснэгт 18. Авлагатай дүүргүүд, сая.төгрөг

	8-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн авлага	Тухайн сард барагдуулсан	8-р сарын эцсийн үлдэгдэл
Багахангай	2.1	1.2	0.0	3.3
Баянгол	40.1	1.6	1.1	40.6
Баянзүрх	2.1	0.0	0.0	2.1
Сонгинохайрхан	4.9	0.0	0.0	4.9
Сүхбаатар	58.8	0.0	3.1	55.6
Чингэлтэй	0.3	0.2	0.0	0.4
Нийслэлийн шууд	441.6	0.0	0.0	441.6
Нийт	549.8	3.0	4.2	548.6

Төсөвт байгууллагууд сарын эхэнд 549.8 сая төгрөгийн авлагатай байснаас тайлант хугацаанд шинээр 3.0 сая төгрөгийн авлага үүсч, тухайн сард 4.2 сая төгрөгийн авлагыг төлж барагдуулан, сарын эцэст 548.6 сая төгрөгийн авлагатай үлджээ.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2015 оны эхний 8 сард нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 23.4 мянган байгууллагын 547.2 мянган иргэд хамрагдаж нийгмийн даатгалын шимтгэл төлжээ.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 364.3 мянга буюу 66.6 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын, 98.4 мянга буюу 18.0 хувь нь төсөвт байгууллагын, 84.4 мянга буюу 15.4 хувь нь сайн


дурын даатгуулагчид байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буюу 7.9 мянган хүнээр буурчээ.

Нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 95.0 хувиар биелүүлж, нийгмийн даатгалын санд нийт 468.2 тэрбум төгрөг хуримтлуулсан байна.

Зураг 23. Даатгалын сангийн орлого, сая төгрөг



Зураг 24. Даатгалын сангийн зарлага



Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 63.8 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 18.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 7.2 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 8.5 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 1.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангаас энэ оны эхний 8 сард даатгуулагч, иргэдэд 593.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сургалтын болон эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгожээ.

Нийт зардлын 69.8 хувийг тэтгэврийн, 15.2 хувийг эрүүл мэндийн, 7.1 хувийг ҮОМШӨ-ний, 6.1 хувийг тэтгэмжийн, 1.8 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч иргэдийн тоо 8 дугаар сард 142.1 мянга, олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 347.8 тэрбум төгрөгт хүрчээ.

Олгосон нийт тэтгэврийн 73.4 хувийг өндөр насны, 10.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.2 хувийг тэжээгчээ алдсаны, 13.0 хувийг цэргийн тэтгэвэрт зарцуулсан байна.



## ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн яамны захиргааны статистик мэдээгээр дүүргийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо нийслэл хотод 2015 оны 8 дугаар сарын эцэст 10443 болж, өмнөх оны мөн үеэс 23.7 хувь буюу 3240 хүнээр буурчээ. Нийт ажилгүйчүүдийн 5742 буюу 55.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг 25. Дүүргийн ажилгүйчүүд, УБ хотын дүнд эзлэх хувь



Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 21.2 хувь буюу 2209 нь 15-24 насны, 38.0 хувь буюу 3971 нь 25-34 насны, 22.2 хувь буюу 2316 нь 35-44 насны, 18.6 хувь буюу 1947 нь 45-аас дээш насны хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 20.8 хувь буюу 2173 нь Чингэлтэй, 18.9 хувь буюу 1970 нь Сүхбаатар, 14.5 хувь буюу 1516 нь Баянзүрх, 13.1 хувь буюу 1374 нь Сонгинохайрхан, 13.0 хувь буюу 1354 нь Хан-Уул, 7.6 хувь буюу 793 нь Налайх, 6.8 хувь буюу 708 нь Баянгол, 4.2 хувь буюу 441 нь Багануур, 1.1 хувь буюу 114 нь Багахангай дүүрэгт тус тус амьдарч байна.

2015 оны 8-р сард ажилгүй 3198 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 868 иргэн ажилд зуучлагдан орж, 3663 иргэн бүртгэлээс хасагджээ.

2015 оны эхний 8 сард 29954 хүн дүүргийн хөдөлмөрийн хэлтэст ажилд орохоор шинээр бүртгүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 10.8 хувь буюу 2931 хүнээр өсчээ.

2015 оны эхний 8 сард 5877 хүн хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулан ажилд орсны 2.0 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 4.9 хувь нь төсөвт байгууллагад, 93.1 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд оржээ.

Хүснэгт 19. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр /9-р сарын 1-ний байдлаар/

	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2013 он	2014 он	2015 он	2013 он	2014 он	2015 он
Нийт ажилгүйчүүд	11602	13683	10443	100	100	100
Үүнээс: дээд боловсролтой	4762	5887	3710	41.0	43.0	35.6
Тусгай дунд боловсролтой	1060	905	743	9.1	6.6	7.1
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	731	698	587	6.3	5.1	5.6
Ерөнхий боловсролтой	4984	6134	5339	43.0	44.8	51.1
Мэргэжилгүй	65	59	64	0.6	0.5	0.6



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

2015 оны эхний 8 сард 27747 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 55 хүүхдээр олон байна. Нийт төрсөн хүүхдийн 12.8 хувь буюу 3546 нь бусад аймгийн харьяат эхчүүдээс төрсөн байна.

Хүснэгт 20. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, эхний 8 сард

	2013 он	2014 он	2015 он	$\frac{2015}{2014} \%$
Амаржсан эхийн тоо	26328	27440	27531	100.3
Амьд төрсөн хүүхэд	26522	27692	27747	100.2
Эхийн эндэгдэл	15	11	7	63.6
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	346	399	414	103.8
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.04	14.41	14.92	103.5

Нялхсын эндэгдлийн 26.9 хувь буюу 77 нь Сонгинохайрхан, 24.1 хувь буюу 69 нь Баянзүрх, 11.9 хувь буюу 34 нь Баянгол, 11.2 хувь буюу 32 нь Хан-Уул, 10.8 хувь буюу 31 нь Чингэлтэй, 10.5 хувь буюу 30 нь Сүхбаатар, 3.1 хувь буюу 9 нь Налайх, 1.1 хувь буюу 3 нь Багануур, 0.4 хувь буюу 1 нь

Багахангай дүүрэгт тус тус гарсан байна. Нялхсын эндэгдлийн 30.9 хувь буюу 128 нь бусад аймгийн харьяат байна. Өмнөх оны мөн үеэс нялхсын эндэгдэл 0.51 промилээр өсчээ.

Зураг 26. Халдварт өвчнөөр өвчлөгсөд, сараар



Нийслэлд 2015 оны эхний 8 сард 31983 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.8 дахин буюу 20456 хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 155.34 продицимилээр тус тус өсчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 58.9 хувийг улаан бурхан, 8.4 хувийг тэмбүү, 7.6 хувийг салхинцэцэг, 5.9 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.2 хувийг заг

хүйтэн, 3.7 хувийг цусан суулга, 3.5 хувийг трихомониаз, 2.7 хувийг гар хөл амны өвчин, 1.0 хувийг вируст гепатит, 0.9 хувийг улаан эсэргэнэ, 0.4 хувийг хоолны хордлого өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

Хүснэгт 21. Нийслэлд гарсан халдварт өвчин, эхний 8 сард

	хэмжих нэгж	2014 он	2015 он	өсөлт, бууралт	
				тоо/пункт	Хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн бүх хүн, үүнээс	бодит тоо	11527	31983	20456	2.8 дах
	10000 хүнд	92.44	247.78	155.34	
Вируст гепатит	бодит тоо	377	325	- 52	- 13.8
	10000 хүнд	3.02	2.52	- 0.5	
Менингит	бодит тоо	5	3	- 2	- 40.0
	10000 хүнд	0.04	0.02	- 0.02	
Цусан суулга	бодит тоо	1096	1178	82	7.5
	10000 хүнд	8.79	9.13	0.34	
Салхин цэцэг	бодит тоо	1660	2427	767	46.2
	10000 хүнд	13.31	18.80	5.49	
Гахай хавдар	бодит тоо	164	60	- 104	- 2.7 дах
	10000 хүнд	1.32	0.46	- 0.86	
Сальмонеллэз	бодит тоо	51	46	- 5	- 9.8
	10000 хүнд	0.41	0.36	- 0.05	
Улаан эсэргэнэ	бодит тоо	150	289	139	1.9 дах
	10000 хүнд	1.20	2.24	1.04	
Улаан бурхан	бодит тоо		18850	18850	-
	10000 хүнд		146.04	146.04	
Хоолны хордлого	бодит тоо	88	133	45	1.5 дах
	10000 хүнд	0.71	1.03	0.32	
Ёлом	бодит тоо	60	63	3	5.0
	10000 хүнд	0.48	0.49	0.01	
Бруцеллэз	бодит тоо	9	12	3	33.3
	10000 хүнд	0.07	0.09	0.02	
Нярайн халдвар	бодит тоо	3	3	-	-
	10000 хүнд	0.02	0.02	-	
Гар хөл амны өвчин	бодит тоо	1157	863	- 294	- 25.4
	10000 хүнд	9.28	6.69	- 2.59	
Тэмбүү	бодит тоо	2295	2695	400	17.4
	10000 хүнд	18.40	20.88	2.48	
Заг хүйтэн	бодит тоо	945	1339	394	41.7
	10000 хүнд	7.58	10.37	2.79	
Трихомониаз	бодит тоо	1075	1111	36	3.3
	10000 хүнд	8.62	8.61	- 0.01	
Шинээр илэрсэн сүрьеэ	бодит тоо	1897	1872	- 25	- 1.3
	10000 хүнд	15.21	14.50	- 0.71	
ДОХ	бодит тоо	26	9	- 17	- 2.9 дах
	10000 хүнд	0.21	0.07	- 0.14	





## ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Нийслэлийн хүн амд 2015 оны эхний 8 сард 22.1 сая м<sup>3</sup>, аж ахуйн нэгж, байгууллагад 7.5 сая м<sup>3</sup> цэвэр усыг борлуулжээ. Борлуулсан усны нийт хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.0 хувиар буурсан байна.

### Хүснэгт 22. Ус суваг ашиглалтын үйлчилгээ


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014 он VIII сар	2015 он VIII сар	$\frac{2015}{2014}$ %
Шахсан ус	мян.м <sup>3</sup>	36063.5	34687.9	96.2
Борлуулсан ус	мян.м <sup>3</sup>	29924.8	29614.6	99.0
Хүн амд	мян.м <sup>3</sup>	21717.0	22123.0	101.9
ААНБ-д	мян.м <sup>3</sup>	8207.8	7491.6	91.3
Татан зайлуулсан бохир	мян.м <sup>3</sup>	29152.3	28913.4	99.2
Хүн амаас	мян.м <sup>3</sup>	20147.1	20504.0	101.8
ААНБ-аас	мян.м <sup>3</sup>	9005.2	8409.4	93.4
Ус борлуулалтын орлого	сая төг	11492.1	17360.6	151.1
Хүн амаас	сая төг	6443.4	10193.7	158.2
ААНБ-аас	сая төг	5048.7	7166.9	142.0
Сувагжуулалтын орлого	сая төг	6484.5	10354.2	159.7
Хүн амаас	сая төг	3081.8	4559.9	148.0
ААНБ-аас	сая төг	3402.7	5794.3	170.3

Нийт борлуулсан усны 75.3 хувийг хүн амд борлуулсан ус, 24.7 хувийг аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан ус тус тус эзэлжээ.


Хүн амд түгээсэн цэвэр усны 96.0 хувь буюу 21.2 сая.м<sup>3</sup> усыг төвлөрсөн шугамаар, 877.6 мян.м<sup>3</sup> усыг ус түгээх байраар, 8.4 мян.м<sup>3</sup> усыг тээврээр түгээв.

Цэвэрлэх байгууламжаар 36.3 сая.м<sup>3</sup> бохирыг цэвэрлэж, аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн 28.9 сая.м<sup>3</sup> бохир шингэнийг татан зайлуулсан байна.

Зураг 27. Борлуулсан ус, сараар, мян.м<sup>3</sup>



Зураг 28. Татан зайлуулсан бохир, сараар, мян.м<sup>3</sup>



**АМЬДАРЧ БУЙ ОРЧИН** Нийслэлийн агаарын дундаж температур 2015 оны 8-р сард дунджаар 18.8<sup>0</sup>С байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.5<sup>0</sup>С-аар, олон жилийн дундажтай харьцуулбал 2.8<sup>0</sup>С-аар тус тус дулаан байлаа. Энэ сард үнэмлэхүй их температур 33.7<sup>0</sup>С, үнэмлэхүй бага температур 7.8<sup>0</sup>С, хур тунадасны нийлбэр 30.8 мм, салхины үнэмлэхүй их хурд 22 м/секунд хүрч, шороон шуургатай 3 өдрийн бүртгэжээ.

Хүснэгт 23. Агаарын бохирдолт, мг/м<sup>3</sup>, 8-р сард


Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдол /тоо/	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO <sub>2</sub>	0.020	253	0.020	-	0.006
Азотын давхар исэл	NO <sub>2</sub>	0.040	209	0.064	44	0.027
Тоосжилт	PM <sub>10</sub>	0.100	229	0.314	78	0.087
	PM <sub>2.5</sub>	0.050	139	0.076	5	0.024
Нүүрстөрөгчийн дутуу исэл	CO	10.000	520	5.363	-	0.462
Озон	O <sub>3</sub>	0.100	458	0.108	1	0.043

\*- Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар


Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2015 оны 8-р сард Улаанбаатар хотын Баруун дөрвөн зам орчимд 22 удаа, 13-р хороолол орчимд 18 удаа, Офицеруудын ордон орчимд 3 удаа, 1-р хороолол орчимд 1 удаа, Озоны 8 цагийн дундаж агууламж Толгойт орчимд 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давжээ.

10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Телевиз орчимд 19 удаа, Нисэх орчимд 18 удаа, Толгойт орчимд 14 удаа, 32-ын тойрог орчимд 9 удаа, Хархорин орчимд 8 удаа, Баруун 4 зам орчимд 7 удаа, Мишээл экспо орчимд 2 удаа, 13-р хороолол орчимд 1 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 2 удаа, 13-р хороолол, Нисэх болон Телевиз орчимд тус бүр 1 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.


Зураг 29. Хүхэрлэг хийн агууламж, мг/м<sup>3</sup>




Зураг 30. Азотын давхар ислийн агууламж, мг/м<sup>3</sup>



Зураг 31. Тоосны /PM<sub>10</sub>/ агууламж, мг/м<sup>3</sup>



Зураг 32. Нүүрстөрөгчийн дутуу исэл, мг/м<sup>3</sup>



Туул голын усны найрлага Туул-Зайсан харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж их бохирдолтой, амоны азот хэвийн, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 4.5 дахин, нитридийн нэгдэл 1.6 дахин, эрдэс фосфор 1.1 дахин хүлцэх хэм хэмжээнээс хэтэрч Туул голын ус маш бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 24. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м<sup>3</sup>, 8-р сард

	Стандарт хэмжээ	“Туул-Зайсан” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
		Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч (O <sub>2</sub> )	≥6	8.06	хэвийн	4.73	горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ <sub>5</sub> )	≤ 3	0.8		13.6	4.5 дахин
Нитридийн нэгдэл (NO <sub>2</sub> )	≤ 0.02	0.003		0.032	1.6 дахин
Амоны азот (NH <sub>4</sub> )	≤0.5	0.13		0.08	хэвийн
Эрдэс фосфор (P)	≤0.1	0.009		0.113	1.1 дахин

\*- Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

**Байгаль орчны зөрчил** Нийслэлд 2015 оны эхний 8 сард байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 430 зөрчлийг илрүүлжээ.

Илрүүлсэн нийт зөрчлийн 31.4 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 30.0 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 20.2 хувийг газрын зөрчил, 5.8 хувийг ойн зөрчил, 3.7 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 2.8 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 2.6 хувийг ангийн зөрчил, 1.9 хувийг ургамал, хөрсний бохирдлын зөрчил, 1.6 хувийг бусад зөрчлүүд эзэлж байна.

Илрүүлсэн нийт зөрчилд 68.6 сая төгрөгийн торгууль ногдуулж, ойн зөрчлөөс 1.9 сая төгрөг, ангийн зөрчлөөс 30.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр, ойн зөрчил гаргасан иргэдээс 14.1 сая төгрөгийн эд зүйлс хураан авчээ.

Хүснэгт 25. Байгаль орчны зөрчил, төрлөөр

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2014 оны эхний 8 сард			2015 оны эхний 8 сард		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль /сая.төг/
Ой	29	10	5.4	16	25	8.6
Ан, амьтан	4	2	-	6	11	1.3
Газрын	49	13	12.6	12	87	20.7
Ус	3	1	3.6	3	1	-
Ургамал, хөрсний бохирдол	6	5	-	5	8	0.6
Агаар, химийн хорт бодис	39	2	1.1	25	129	3.1
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	71	34	11.5	15	16	7.5
Геодези зураг зүй, кадастр	26	15	0.8	7	135	9.7
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	1	1	4.8	5	12	15.4
Бусад	26	32	4.3	11	6	1.7
Бүгд	254	115	44.1	105	430	68.6

Хүснэгт 26. Агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м<sup>3</sup>, 8-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	1-р хороолол	13-р хороолол	32-ын тойрог	Офицеруу- дын ордон	Хархорин зах	Ургах наран хороолол	Нисэх	Толгойт	Телевиз	Амгалан
Хүхэрлэг хий SO <sub>2</sub>	Дундаж	-	0.006	0.002	0.005	0.002	0.000	0.003	-	0.013	0.009	0.007	-
	Хамгийн их	-	0.012	0.007	0.009	0.007	0.006	0.006	-	0.020	0.019	0.012	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	31	29	15	29	27	30	-	30	31	31	-
Азотын давхар Исэл NO <sub>2</sub>	Дундаж	-	0.051	0.020	0.050	0.021	0.023	-	-	0.009	0.012	0.027	-
	Хамгийн их	-	0.063	0.057	0.064	0.034	0.056	-	-	0.015	0.020	0.035	-
	XXX*-с давсан хувь	-	92.0	5.0	90.0	-	13.0	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	24	22	20	28	23	-	-	30	31	31	-
Нүүрс- төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж	-	1.087	-	0.318	-	-	0.367	-	0.254	0.269	0.476	-
	Хамгийн их	-	5.363	-	0.738	-	-	1.288	-	0.573	0.613	0.976	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	93	-	61	-	-	88	-	92	93	93	-
Тоос PM10	Дундаж	0.060	0.085	-	0.067	0.095	-	0.087	-	0.097	0.095	0.110	-
	Хамгийн их	0.162	0.129	-	0.106	0.314	-	0.205	-	0.198	0.203	0.185	-
	XXX*-с давсан хувь	7.0	23.0	-	5.0	29.0	-	29.0	-	60.0	45.0	61.0	-
	Хэмжилтийн тоо	28	30	-	20	31	-	28	-	30	31	31	-
Тоос PM2.5	Дундаж	-	0.016	-	0.029	-	-	-	-	0.023	0.025	0.026	-
	Хамгийн их	-	0.026	-	0.076	-	-	-	-	0.051	0.068	0.059	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	5.0	-	-	-	-	3.0	7.0	3.0	-
	Хэмжилтийн тоо	-	27	-	20	-	-	-	-	30	31	31	-
Озон O <sub>3</sub> **	Дундаж	0.033	-	-	0.041	0.035	-	-	-	0.027	0.067	0.056	-
	Хамгийн их	0.096	-	-	0.082	0.082	-	-	-	0.067	0.108	0.098	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-	-	-	-	1.0	-	-
	Хэмжилтийн тоо	50	-	-	37	93	-	-	-	92	93	93	-

\*- Х□лцэх хэм хэмжээ, \*\*- CO, O<sub>3</sub>-ийн хэмжилтийг 8 цагийн дундажаар тооцсон.



## ХОТЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2015 оны эхний 8 сард нийт 335 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өссөн байна. Нийт гамшиг ослын 330 нь хүний үйл ажиллагаатай холбоотой осол, харин 4 тохиолдол нь ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, 1 тохиолдол нь гахайн мялзан өвчин байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой сум галт хэрэгслийн осол 1, химийн бодисын осол 14, бичил уурхай, нурангины осол 2, усны осол 28, барилгын осол 6, үйлдвэрийн осол 2, бусад осол 277 гарсан байна. Ослоос 171 хүнийг аварч, ослын уршгийг арилгах ажилд нийт 3.4 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 27. Гал түймрийн тоо, дүүргээр

Дүүрэг	2014 он	2015 он	$\frac{2015}{2014}$ %
Бүгд	1860	2435	130.9
Багануур	24	40	166.7
Багахангай	4	8	200.0
Баянгол	293	313	106.8
Баянзүрх	431	597	138.5
Налайх	69	56	81.2
Сонгинохайрхан	353	531	150.4
Сүхбаатар	286	342	119.6
Хан-уул	182	238	130.8
Чингэлтэй	218	310	142.2

Нийслэл хотод 2015 оны эхний 8 сард ой хээрийн 23 түймэр, ахуйн 2435 гал түймэр гарчээ. Ахуйн гал түймэр өмнөх оны мөн үеэс 30.9 хувиар нэмэгдсэн байна.

Гал түймрийн улмаас 22 хүн (үүнээс, хүүхэд 6) амь насаа алдаж, 21 хүн (үүнээс, хүүхэд 8) түлэгдэж гэмтжээ. Гал түймрийн аюулаас 384 хүн, 644 байшин барилга, 4.6 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварчээ.


Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 386, санамсаргүй байдлаас 1796, санаатай үйлдлээр 1, шалтгаан тогтоогдоогүй 168, бусад шалтгаанаар 84 гал түймэр гарсан байна.

Гал түймэрт 641 гэр, орон сууц, 341 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 103 машин техник, 88 малын хашаа, саравч, бусад төрлийн 1262 объект өртсөн байна. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 1573, төрийн өмчийн 722, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 139, гадаадын хөрөнгө оруулалттай 1 объект өртөж, нийт 11.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Зураг 33. Гал түймэр, шалтгаанаар



Зураг 34. Гал түймэр, байршлаар



Нийслэлийн Онцгой байдлын газраас 2015 оны эхний 8 сард 143 барилгын зураг төсөл, ашиглалтанд хүлээн авч буй 347 барилгад хяналт тавьж ажиллажээ. Мөн 11300 айл өрх, 7091 объектод үзлэг шалгалт хийж, 31051 галын зөрчил илрүүлж, 141 байгууллагын үйл ажиллагааг нь зогсоож, байгууллага, албан тушаалтан, иргэнд 1823 заавал биелүүлэх албан шаардлага, 2259 мэдэгдэл хүргүүлж, 40.6 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.



## ГЭМТ ХЭРЭГ

2015 оны эхний 8 сард 12203 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 11.7 хувь буюу 1276 хэргээр өсчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 57.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр дээгүүр байна.

Зураг 35. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Гэмт хэргийн улмаас 4415 хүн гэмтэж осолдож, 296 хүн нас барж, төр ард иргэдэд 60.9 тэрбум төгрөгийн хохирол учруулсны 25.4 хувь буюу 15.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 33.0 хувийг хулгайн, 25.8 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 9.3 хувийг залилан, 6.8 хувийг танхайн, 6.3 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 28. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, төрлөөр, эхний 8 сард

	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Хүний амь	73	73	-	-
Хүчин	101	84	- 17	- 16.8
Дээрэм	409	292	- 117	- 28.6
Хулгай	3316	4026	710	21.4
Булаалт	135	137	2	1.5
Залилан	878	1134	256	29.2
Хүний эрх, эрх чөлөөний эсрэг	3152	3147	- 5	- 0.2
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	638	772	134	21.0
Бусдыг амиа хорлоход хүргэх	149	151	2	1.3
Ашиглах	113	113	-	-
Танхайрах	890	830	- 60	- 6.7
Бусад	1073	1444	371	34.6
<b>БҮГД</b>	<b>10927</b>	<b>12203</b>	<b>1276</b>	<b>11.7</b>

2015 оны эхний 8 сард 37092 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 15.6 хувь буюу 6830 хүнээр буурсан байна.



Хүснэгт 29. Нийт бүртгэсэн гэмт хэрэг, дүүргээр, эхний 8 сард

дүүрэг	Нийт бүртгэсэн гэмт хэрэг		Гэмт хэргийн өсөлт, бууралт	
	2014 он	2015 он	Тоо	Хувь
Багануур	160	219	59	36.9
Багахангай	13	19	6	46.2
Баянгол	1744	1886	142	8.1
Баянзүрх	2644	2946	302	11.4
Налайх	221	308	87	39.4
Сонгинохайрхан	2007	2166	159	7.9
Сүхбаатар	1585	2111	526	33.2
Чингэлтэй	1566	1606	40	2.6
Хан-Уул	987	942	- 45	- 4.6
ДҮН	10927	12203	1276	11.7

Хүснэгт 30. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2015 оны эхний 8 сард


дүүрэг	Сэжигтэн тодорхойгүй хэргийн тоо	Үүнээс сэжигтнийг илрүүлж ял сонгосон	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
Багануур	69	36	52.2
Багахангай	1	-	0.0
Баянгол	725	485	66.9
Баянзүрх	1847	1001	54.2
Налайх	87	62	71.3
Сонгинохайрхан	1330	743	55.9
Сүхбаатар	1287	735	57.1
Чингэлтэй	1053	600	57.0
Хан-Уул	391	254	65.0
ДҮН	6790	3916	57.7

Хүснэгт 31. Бүртгэсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, эхний 8 сард

дүүрэг	Нийт хулгайн гэмт хэргийн тоо		Үүнээс: хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо	
	2014 он	2015 он	2014 он	2015 он
Багануур	25	56	22	41
Багахангай	3	2	2	1
Баянгол	467	427	370	346
Баянзүрх	873	1080	749	945
Налайх	39	74	32	64
Сонгинохайрхан	676	855	612	787
Сүхбаатар	491	795	375	611
Чингэлтэй	469	508	426	433
Хан-Уул	273	229	239	215
ДҮН	3316	4026	2827	3443

2015 оны эхний 8 сард онц хүнд хэрэг 220, хүнд хэрэг 729 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2-14.3 хувиар буурч, харин хөнгөн хэрэг 5776, хүндэвтэр хэрэг 5478 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.9-14.9 хувиар өсчээ.

Зураг 36. Гэмт хэргийн тоо, ангиллаар



Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 9330 болж, 2014 оны мөн үеэс 10.3 хувь буюу 874 хүнээр өссөн байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 12.5 хувь буюу 1166 нь гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн, 16.3 хувь буюу 1524 нь согтуугаар үйлдсэн, 5.2 хувь буюу 485 нь урьд ямар нэг ял шийтгэл хүлээж байсан хүмүүс үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 5.2 хувь буюу 483 нь хүүхэд, 17.9 хувь буюу 1670 нь эмэгтэйчүүд байна.

### НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР